



Монголд уул уурхайн бирж байгуулах боломж

“Уул уурхайн салбарын маркетинг ба борлуулалт” судалгааны
нэмэлт судалгаа

3. Манлайбаатар /Эдийн засгийн судалгаа,
эрдэм шинжилгээний хүрээлэн/

2020-09-30

Агуулга

1. Оршил
2. Уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалт
3. Уул уурхайн бирж байгуулах урьдач нөхцөлийн үнэлгээ
4. Уул уурхайн бирж байгуулах бусад хувилбар
5. Дүгнэлт

1. Оршил

- Дотоодод уул уурхайн бирж (УУБ) байхгүй байгаа нь салбарын нэг гол бэрхшээл (“Уул уурхайн салбарын маркетинг ба борлуулалт”, ЭЗСЭШХ, 2018)
 - Борлуулалтын гэрээ ил тод биш, төсвийн орлого алдагдах
 - Үйлдвэрлэгчид зах зээлийн эцсийн үнээс ямар хувь хүртэж буйгаа мэдэхгүй
 - Зуучлагчид ашгаас хэт их хувь хүртдэг
- УУБ байгуулах нь үр дүнтэй нэг шийдэл байж болох юм
 - Агуулахын баримт худалдах – өмчлөх эрхийг хялбар солилцоно
 - Спот гэрээ худалдах – түүхий эд борлуулах, чанар шалгах өртгийг бууруулж, мэдээллийг нээлттэй болгож, үйлдвэрлэгчдийн үнийн зөрүүг ойртуулж, түүхий эд боловсруулалтыг дэмждэг.
 - Форвард, опцион, фючерс гэрээ худалдах – зах зээлийн хөрвөх чадварыг дээшлүүлж, үнийн эрсдэлийг удирдах боломж олгодог.
- Гэвч дэмжих институц, дэд бүтцийн хөрөнгө оруулалт шаардлагатай

1. Оршил

- “Уул уурхайн бирж байгуулах боломж”, Монголын Экспортлогчдын Холбоо (2013) – олон улсын жишиг, дотоодын хэрэгцээ, биржээр арилжаалах бүтээгдэхүүн, тээвэр, агуулахын дэлгэрэнгүй судалгаа, бодлогын санал
- “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого 2014-2025”, УИХ (2014) – эрдэс баялгийн бирж байгуулахаар заасан
- 2013 онд Хөдөө Аж Ахуйн Биржийг ноолуур, ноос, буудай, амьд мал зэрэг бүтээгдэхүүн арилжаалах зорилгоор байгуулсан
- Энэ судалгааны хүрээнд:
 - Уул уурхайн биржийн талаарх олон улсын ба дотоодын судалгааны ажлуудын тойм
 - Гол оролцогч талуудтай хийсэн ярилцлага (УУХҮЯ, СЗХ, ХААБ, ЭТТ)

2. Уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалт

- Уул уурхайн салбарын Монголын эдийн засагт оруулах хувь нэмэр өссөн:
 - 2018 оны байдлаар, ДНБ-ий 23.5%, төсвийн орлогын 32.9%, экспортын 86.6%
 - Нүүрсний нөөц 27.9 тэрбум тн, жонш 16.8 сая тн, төмөр 350 сая тн, зэс 53.6 сая тн, цайр 1.2 сая тн (EITI Mongolia, 2018).
- Түүхий эд тус бүрийн зах зээлийн үнэ бүрдэлт, борлуулалтын механизм ялгаатай
 - Алтыг Монголбанк худалдан авч олон улсын зах зээлд борлуулдаг
 - Бусад түүхий эдийг гол төлөв зуучлагчдаар дамжуулан БНХАУ-д борлуулдаг
 - Борлуулалтын гэрээний талаарх мэдээлэл ил тод биш

2. УУ-н бүтээгдэхүүний борлуулалт: Нүүрс

- Нүүрсний экспортын үнэ маш их зөрүүтэй
- Нэг ордоос экспортолж буй бүтээгдэхүүний борлуулалт ч маш их ялгаатай

Таван толгой ордын нүүрсний борлуулалт, 2018 он

	Тайлбар	Хэмжээ (сая тн)	Орлого, сая ам.доллар	Дундаж үнэ, ам.доллар/тн
Энержи ресурс (Угаасан коксжих болон эрчим хүчний нүүрс)	Хятадын эцсийн хэрэглэгчид	4.7	591 сая	170.1
	Гашуун сухайт боомтоор			135.6
Эрдэнэс таван толгой	Уурхайн үйлчилгээний төлбөрт	1.7	803.5 сая*	-
	Дуудлага худалдаагаар	7.9		68.1 - 72.2
	Чалко руу шууд	3.47		59.3 - 61.0
Таван толгой ХК	Экспорт	1.70	91.4 сая*	53.8*
	Дотоодын зах зээл	0.14	0.1 сая*	6.1*

* - 2018 оны дундаж ханш 1 ам.доллар = 2472.67 төгрөг

Эх сурвалж: Mongolian Mining Corporation, Эрдэнэс таван толгой, Таван толгой ХК-ийн жилийн тайлан

2. УУ-н бүтээгдэхүүний борлуулалт: Зэс

- Эрдэнэт, Оюу Толгой баяжмалаа БНХАУ-д экспортолдог
- Эрдэнэт – 13 зуучлагч компанитай гэрээтэй
 - Зуучлагчидтай 3 жилийн гэрээтэй, үнээ жил бүр шинэчилдэг
 - Тээвэрлэхээс 5-7 хоногийн өмнө 95%-ийн урьдчилгааг дотоодын банкны дансанд хүлээж авдаг
 - Гэрээнд дэлхийн зах зээлийн хамгийн бага 3 сарын үнийг ашигладаг
 - Хайлах, цэвэршүүлэх зардлын (ТС/РС) хасалт= тн тутамд \$103.5 (Хятадын дунджаас 10-35% өндөр)
- Оюу Толгой – 5 зуучлагч компанитай гэрээтэй
 - Зуучлагчидтай 5-8 жилийн гэрээтэй
 - Хайлах, цэвэршүүлэх зардлын хасалт Хятадын дундажтай ойролцоо
 - Хайлуулах үеийн хорогдуулга Эрдэнэт (1.1%)-ээс 2 дахин их

Эх сурвалж: (Mongolian Mining Journal, 2014, №9)

2. УУ-н бүтээгдэхүүний борлуулалт: Бусад

- **Төмрийн хүдэр** - гол зах зээл Хойд Хятад
 - 2018 онд хилийн дундаж үнэ 46\$/тн; дэлхийн дундаж үнэ 70\$ (АМГТГ)
- **Газрын тос** – 2 компани олборлож БНХАУ-д экспортолдог
 - Петрочайна Дачин Тамсаг салбар компани руугаа шууд тээвэрлэдэг, үнийг Сингапурын түүхий эдийн биржийн ханшаар тооцдог.
 - Донгшенг Петролеум Лондоны түүхий эдийн биржийн DTD брент маркийн үнээс 3.62 ам.доллар доогуур үнээр борлуулдаг.
- **Цайрын баяжмал** – 2 компани олборлож БНХАУ-д экспортолдог
 - Цайрт минерал China Nonferrous Metal Industry группт, Лондоны металлын биржийн ханшаар борлуулдаг, ТС/РС тодорхойгүй

3. УУБ байгуулах урьдач нөхцөлийн үнэлгээ

- Хөгжингүй орнуудад түүхий эдийн биржийн арилжаа удаан түүхтэй
- Зүүн Европ, Төв Азид түүхий эдийн 200 бирж ажиллаж байгаа боловч хөгжлийн түвшин доогуур
- Түүхий эдийн бирж байгуулахад шаардлагатай урьдач нөхцөлүүд (Rashid, et al., 2010) :
 - Дотоодын зах зээлийн хэмжээ
 - Биет болон харилцаа холбооны дэд бүтэц
 - Мэдээллийн технологи
 - Хууль, зохицуулалтын тааламжтай орчин
 - Улс төрөөс бизнест хэт оролцохгүй байх
- Их хэмжээний арилжаа, бага шимтгэл зайлшгүй → зуучлагчдыг олноор татах, бүс нутгийн бусад биржтэй өрсөлдөх

3. УУБ байгуулах урьдач нөхцөлийн үнэлгээ

- Монгол Улс бүс нутагтаа бизнесийн өрсөлдөх чадвар муутай байна.

Дэлхийн өрсөлдөх чадварын индекс, 140 орны эрэмбэ

	Дэд бүтэц	Мэдээллийн технологи	Ур чадвар	Бизнес динамизм	Макро эдийн засгийн тогтвортой байдал	Санхүүгийн систем
Монгол	103	78	109	89	121	89
Казакстан	69	44	100	37	62	57
БНХАУ	29	26	30	43	39	63
ОХУ	51	25	86	51	55	50

Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн форум (2019)

Логистик гүйцэтгэлийн индекс, 2018

	Нийт оноо	Гааль	Дэд бүтэц	ОУ-ын тээвэрлэлт	Логистик чадавх	Хянах, мөшгөх	Хугацаан даа байх
Монгол	2.40	2.25	2.12	2.45	2.23	2.21	3.07
Казакстан	2.77	2.57	2.59	2.73	2.60	2.81	3.31
БНХАУ	3.6	3.28	3.73	3.57	3.58	3.63	3.86
ОХУ	2.69	2.25	2.64	2.59	2.74	2.67	3.23

Эх сурвалж: Дэлхийн банк (2018)

3. УУБ байгуулах урьдач нөхцөлийн үнэлгээ

- Монголын санхүүгийн зах зээл үр ашиггүй, хөрвөх чадвар муутай

2018 оны санхүүгийн салбарын үзүүлэлтүүд, %

	Зээлийн хүү	Зээл - хад.ж хүү зөрүү	Зээлийн бодит хүү	Дотоодын хувийн секторт олгосон зээл/ДНБ	Дотоодын хувийн секторт банкнаас олгосон зээл/ДНБ
Монгол	17.7	5.3	7.8	56.2	54.2
Казакстан	12.3	4.9	4.7	27.3	23.8
БНХАУ	4.4	2.9	2.1	161.1	161.1
ОХУ	8.9	3.5	1.3	76.0	51.3

Эх сурвалж: World Development Indicators; National Bank of Kazakhstan

- Гэрээний хэрэгжилт, Монголын эзлэх байр (68) Казакстан (4), БНХАУ (6), ОХУ (18)-аас доогуур

Гэрээний хэрэгжилт

	2016	2017	2018	2019
Эрэмбэ (нийт улсын тоо)	80 (189)	85 (190)	88 (190)	68 (190)
Оноо (0-100)	59.4	58.5	58.5	60.9
Хугацаа (хоног)	374	374	374	374
Зардал (нэхэмжилсэн дүнд харьцуулах хувь)	30.6	30.6	30.6	26.5
Шүүхийн үйл ажиллагааны чанар (0-18)	6	5.5	5.5	8

Эх сурвалж: Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй”

3. УУБ байгуулах урьдач нөхцөлийн үнэлгээ

- УУБ байгуулах бодлого тогтворгүй
 - 2014 оны Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, ЗГ-ын 211-р тогтоолд УУБ-ийг хувийн хөрөнгө оруулалтаар байгуулахыг заасан
 - УУБ нь Үнэт цаасны зах зээлийн хууль, Хөдөө аж ахуйн биржийн хуулиар зохицуулагдахгүй
 - 2016 онд ЗГ-аас УУБ-ийн хуулийн төсөл боловсруулах шийдвэр гаргасан ч УИХ-д өргөн бариагүй
 - 2017 оны Хууль тогтоомжийг батлах үндсэн чиглэлд СЗХ, СЯ-ны ажлын хэсэг УУБ-ийн хуулийн төсөл боловсруулахаар заасан ч хэрэгжилт тодорхойгүй.
 - “Эрдэнэс Монгол” төрийн өмчит компани 2018 онд УУБ байгуулах стратеги баталсан. МҮЦБ (MSX)-тэй хамтарч байгаа.
 - Алсын хараа -2050, ЗГ-ын ү/а-ны хөтөлбөр (2020-2024)-т тусаагүй.

4. УУБ байгуулах бусад хувилбар

- **ХАА-н биржийг өргөтгөх**

- ХААБ нь 100% төрийн өмчит бирж, 11 төрлийн спот гэрээ арилждаг
- 14 брокер (байнгын гишүүн), 58 бэлтгэн нийлүүлэгч (түр гишүүн)
- Түүхий эдийн арилжаа тогтвортой хийгдэж ирсний гол шалтгаан нь экспортлох түүхий эдийг тус биржээр арилжаалсан байх шаардлага юм
- Арилжааны платформ, хүний нөөц бүрдсэн
- Гэхдээ УУБ болгож өргөтгөхийн тулд шинэ дүрэм журмууд, агуулах, лаборатори, логистик төвүүд байгуулах шаардлагатай

ХААБ-ын арилжаа, тн

	2013	2014	2015	2016	2017	2018
Ноолуур	6382	6124	6877	7216	6956	5862
Хонины ноос	1005	7641	10171	16150	10888	13794
Тэмээний ноос	1048	1018	434	774	356	274
Тосны ургамал	14912	12535	-	-	-	-
Завод ноос	-	902	2130	1639	2881	4642
Нийт арилжааны дүн, тэрбум төг.	404	554	432	463	572	711

Эх сурвалж: www.mce.mn

4. УУБ байгуулах бусад хувилбар

- **Үйл ажиллагаа нь тогтворжсон том биржийг ашиглах**
 - Том бирж дээр хеж хийх (hedging) боломж нь эрсдэлийг бууруулж, төлбөрийн чадвар, дэлхийн зах зээлтэй холбогдох боломжийг нэмэгдүүлнэ
 - Хамгийн ойр биржүүд:
 - Шанхай фючерсийн бирж – зэс, цайр
 - Женжоу түүхий эдийн бирж– эрчим хүчний нүүрс, төмрийн хайлш
 - Далиан түүхий эдийн бирж – эрчим хүчний ба коксжих нүүрс, төмрийн хүдэр
 - Сул тал:
 - Түүхий эдийг тухайн биржийн стандартад нийцүүлж боловсруулах, хүчин чадлыг ихээхэн нэмэгдүүлэх шаардлагатай
 - Валютын ханшийн эрсдэл нэмэгдэнэ
 - Хол зайд тээвэрлэх, импортлогч орнуудын дэд бүтэцтэй шууд холбогдох

5. ДүГНЭЛТ

- УУБ байгуулах нь чухал давуу талуудтай:
 - Хэлцлийн зардал буурна, оролцогчдод илүү өгөөжтэй
 - Ил тод гэрээ нийгмийн итгэлцэл, төсвийн орлогыг нэмэгдүүлнэ
 - Олборлогчид гэрээний стандартад нийцүүлэхийн тулд түүхий эдээ боловсруулах сонирхолтой болно
- Гэвч урьдач нөхцөлүүд тааламжгүй:
 - Бизнесийн болон макро эдийн засгийн орчин тааруу
 - УУБ-ийн талаарх бодлого тууштай биш
 - Логистик төв, дэд бүтэц, арилжааны платформд хөрөнгө оруулалт их шаардлагатай
- Төрийн хөрөнгө оруулалтаар (“Эрдэнэс Монгол”) УУБ байгуулах төлөвлөгөөтэй
- Зардал, үр өгөөжийн нарийвчилсан шинжилгээ, ТЭЗҮ хийх шаардлагатай
- Харгалзаж үзэх өөр хувилбарууд:
 1. УУБ-ийг хувийн хөрөнгө оруулалтаар байгуулах
 2. Дотоодын аль нэг биржийг (ХААБ г.м) өргөтгөх
 3. Үйл ажиллагаа нь жигдэрсэн гадаадын томоохон биржтэй хамтрах

Thank you for your attention